



**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

**АЙМГУУДЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТОВЧ
ТАНИЛЦУУЛГА**

**УЛААНБААТАР ХОТ
2018 ОН**

АЙМГУУДЫН ХҮНС, ХӨДӨӨ, АЖ АХУЙН ГАЗРЫН 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2018.02.01

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

1.1. Аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газраас хэрэгжүүлсэн үйл ажиллагааны гүйцэтгэлийн хүрсэн түвшинг тогтоон удирдлагыг бодит мэдээлэл, санал-дүгнэлт, зөвлөмжөөр хангах, мөн түүнчлэн байгууллагын гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хариуцлагыг сайжруулах зорилготой.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилт

2.1. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын бодлогын зорилт нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг тооцно.

2.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн, дүгнэлтийг үндэслэн салбарын байгууллагууд үйл ажиллагааны зорилтоо тодорхойлох төлөвлөгөө, бодлогын хувилбар, санал боловсруулахад дэмжлэг үзүүлэх, агентлагийн дарга, Засаг дарга болон холбогдох байгууллагын удирдлагад шийдвэр гаргахад бодлогын дэмжлэг үзүүлнэ.

2.3. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын байгууллагын стратеги зорилт, үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, төлөвлөлт, гүйцэтгэл, дунд болон урт хугацааны үр дүн, үр нөлөөг сайжруулна.

2.4. Байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн санг бүрдүүлж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангана.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

3.1 Аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны А/159 дүгээр тушаалаар батлагдсан “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ыг удирдлага болгов.

3.2 Ерөнхий үнэлгээний дүнг гаргахдаа бүрэлдэхүүн хэсгүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлэн, нийт дүнд (100) эзлэх итгэлцүүр тогтоосон бөгөөд энэ нь бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнд 20 хувь, байгууллагын чиг үүргийн үзүүлэлтэд 20 хувь, байгууллагын нээлттэй байдлын үнэлгээнд 10 хувь, үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээнд 50 хувь байхаар тус тус тооцов. Бүрэлдэхүүн тус бүрийн үнэлгээг гаргахдаа /дэд хэсгийн/ биелэлтийн дундаж хувиар тооцсон болно.

3.3 Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ аймгуудын үйл ажиллагааны болон хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг судлах, 2016, 2017 оны статистик дүн, яамны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрууд болон харьяа байгууллагуудад аймгуудаас ирүүлсэн

мэдээ, мэдээлэлтэй харьцуулалт хийх болон хариуцсан мэргэжилтнээс тодруулга авч нягтлах зэрэг үндсэн аргуудыг ашиглав.

Мөн тайлангийн чанар, агуулга, мэдээллийн үнэн бодит байдал, заасан хугацааг баримталсан эсэхийг үнэлгээний дүнд харгалзан үзсэн болно.

Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2017 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ 4 бүрэлдэхүүн хэсэг, 12 дэд хэсгийг хамарсан бөгөөд ерөнхий үнэлгээ дунджаар 86.77 хувьтай гарч байна /Нэгдүгээр хүснэгт/.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧОО

Хүснэгт-1

Үзүүлэлт		Хяналт-шинжилгээ, үнэлгээ, хувь
Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ	Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	88.3
	Үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн ЗД, ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт; /ХХАА-н салбарт хэрэгжиж буй 5 дэд хөтөлбөр/	86.6
	Аймгийн эдийн засаг, нийгмийг тухайн онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт;	90.1
	ДУНДАЖ	88.3
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	Төсвийн ерөнхийлөн захирагчаас ХХААГ-ын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт;	80.2
	Сумдын мал эмнэлэг, үржлийн тасгийн тухайн жилийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн үнэлгээ	82.9
	Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлт;	91.6
	ДУНДАЖ	84.9
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын тайлан	94.0
	Хэрэглэгчийн үнэлгээ	76.4
	ДУНДАЖ	86.7
Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ	Хүнсний салбар	86.4
	Мал эмнэлгийн салбар	89.5
	Мал аж ахуйн салбар	91.1
	Газар тариалангийн салбар	82.7
	Хөнгөн, ЖДҮ	86.3
	ДУНДАЖ	87.2
ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ		86.7

АЙМГУУДЫН ХХААГ-ЫН 2017 ОНЫ АЖЛЫН ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ

1/31/2018

№	Аймгууд	Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ /50 оноо/					Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ /20 оноо/					Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ /20 оноо/					Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ /10 оноо/					Үнэлгээний оноо	Эзэлсэн байр	
		Хүнс	Мал эмнэлэг	Мал аж ахуй	Газар тариалан	Хөнгөн, ЖДҮ	Үнэлгээ		Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр Дэд хөтөлбөрүүдийн үнэлгээ	Аймгийн эдийн засаг, нийгмий хөгжүүлэх үндсэн чиглэл	Үнэлгээ		Сайд, ХХААГ-ын даргатай байгуулсан гэрээний ХХААГ, сумын МЭҮТ-тай байгуулсан гэрээний	Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлт	Үнэлгээ		Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын тайлан	Хэрэглэгчийн үнэлгээ	Үнэлгээ					
							ХШҮ, хувь	оноо			хувь	оноо			ХШҮ, хувь	оноо			ХШҮ, хувь	оноо				
1	Архангай	79.1	86.3	83.8	71.3	76.1	79.3	39.7	85.8	85.6	88.0	86.5	17.3	75.3	81.6	87.1	81.3	16.3	95.0	90.0	92.5	9.3	82.48	XXI
2	Баян-Өлгий	91.0	92.7	93.5	76.7	90.0	88.8	44.4	80.6	83.6	80.0	81.4	16.3	81.4	83.5	89.4	84.8	17.0	89.2	96.1	92.7	9.3	86.90	XI
3	Баянхонгор	50.0	91.3	93.6	72.2	90.4	79.5	39.7	88.2	85.1	94.3	89.2	17.8	77.2	70.0	91.3	79.5	15.9	100.0	89.0	94.5	9.5	82.93	XIX
4	Булган	50.0	89.4	95.7	87.6	81.1	80.8	40.4	91.0	93.5	85.0	89.8	18.0	77.6	86.8	94.0	86.1	17.2	95.0	95.6	95.3	9.5	85.11	XVI
5	Говь-Алтай	99.6	88.7	89.6	76.7	87.4	88.4	44.2	88.7	83.4	89.0	87.0	17.4	82.2	84.6	86.3	84.4	16.9	97.5	67.2	82.3	8.2	86.71	XIII
6	Дорноговь	89.3	91.0	90.0	90.1	89.0	89.9	44.9	90.5	90.0	91.5	90.7	18.1	82.0	90.0	93.4	88.5	17.7	90.0	61.6	75.8	7.6	88.35	VII
7	Дорнод	86.5	87.0	92.1	71.6	87.1	84.8	42.4	89.7	97.0	98.2	95.0	19.0	81.3	73.8	95.7	83.6	16.7	90.6	70.0	80.3	8.0	86.17	XV
8	Дундговь	99.1	79.0	90.9	86.2	91.8	89.4	44.7	90.0	92.6	92.1	91.6	18.3	82.7	86.3	94.7	87.9	17.6	92.5	72.0	82.3	8.2	88.82	VI
9	Завхан	93.1	93.8	90.6	86.3	89.2	90.6	45.3	91.9	100.0	94.4	95.4	19.1	81.9	78.4	91.3	83.9	16.8	94.3	74.0	84.1	8.4	89.56	II
10	Өвөрхангай	99.4	92.6	94.8	83.4	94.6	93.0	46.5	87.4	94.0	70.0	83.8	16.8	83.3	90.0	96.2	89.8	18.0	96.3	82.5	89.4	8.9	90.14	I
11	Өмнөговь	79.3	85.5	92.6	87.9	82.4	85.5	42.8	95.0	65.0	92.6	84.2	16.8	77.0	81.4	92.0	83.5	16.7	93.8	80.0	86.9	8.7	84.98	XVIII
12	Сүхбаатар	92.1	93.4	93.1	80.7	89.0	89.7	44.8	82.1	90.0	96.0	89.4	17.9	77.9	83.6	90.6	84.0	16.8	97.1	50.0	73.5	7.4	86.87	XII
13	Сэлэнгэ	67.4	89.4	90.4	93.8	82.8	84.8	42.4	91.1	82.8	90.8	88.2	17.6	81.9	74.4	90.0	82.1	16.4	100.0	97.4	98.7	9.9	86.31	XIV
14	Төв	96.0	94.4	84.7	86.2	86.8	89.6	44.8	93.0	78.0	91.3	87.4	17.5	82.2	84.0	89.2	85.1	17.0	88.3	68.8	78.5	7.9	87.17	VIII
15	Увс	78.9	90.0	94.1	92.0	85.7	88.1	44.1	80.0	90.0	86.5	85.5	17.1	73.1	86.4	91.4	83.6	16.7	93.3	50.0	71.6	7.2	85.06	XVII
16	Ховд	98.9	94.1	90.4	88.0	85.8	91.4	45.7	76.7	88.3	92.5	85.8	17.2	83.4	87.7	89.0	86.7	17.3	93.8	90.1	91.9	9.2	89.42	III
17	Хөвсгөл	80.9	96.0	94.2	83.8	85.6	88.1	44.1	90.6	73.3	88.3	84.1	16.8	80.0	82.8	94.7	85.8	17.2	93.6	84.0	88.8	8.9	86.92	IX
18	Хэнтий	99.8	88.5	94.0	80.2	85.9	89.7	44.8	93.7	92.0	96.6	94.1	18.8	81.6	77.0	91.3	83.3	16.7	86.3	88.0	87.2	8.7	89.03	IV
19	Дархан-Уул	90.0	91.4	85.0	82.6	90.4	87.9	43.9	90.5	90.1	100.0	93.5	18.7	86.3	83.4	90.0	86.6	17.3	95.6	82.5	89.0	8.9	88.86	V
20	Орхон	99.2	85.6	90.0	80.6	86.9	88.5	44.2	90.7	94.0	86.4	90.4	18.1	80.2	85.0	91.9	85.7	17.1	99.5	50.0	74.8	7.5	86.91	X
21	Говьсүмбэр	84.0	90.3	90.8	78.5	75.2	83.8	41.9	88.0	70.0	89.0	82.3	16.5	75.1	79.1	94.8	83.0	16.6	92.7	66.0	79.3	7.9	82.88	XX
	Дундаж	85.9	90.0	91.1	82.7	86.3	87.2	43.6	88.3	86.6	90.1	88.3	17.7	80.2	82.4	91.6	84.7	16.9	94.0	76.4	85.2	8.5	86.74	

4.1. Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ

Уг бүрэлдэхүүн хэсэг нь Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн ЗД, ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт, Аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт гэсэн дэд хэсэгтэй ба эдгээр бодлогын баримт бичигт тусгагдсан салбарт хамаарах арга хэмжээний хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс тухайн зорилт, арга хэмжээг үнэлсэн дүнгээр авсан. “Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ” бүрэлдэхүүн хэсгийн дундаж үнэлгээ **88.3** хувьтай байна.

График-1




Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг өссөн дүнгээр тайлагнасан байна. Цаашид тухайн тайлант жилийн дүнг аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсээр баталгаажуулж ирүүлэх шаардлагатай. Дорноговь, Дорнод, Сэлэнгэ аймгууд аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ээр тайлан баталгаажуулж ирүүлээгүй. Архангай, Төв, Хөвсгөл аймгууд аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн биелэлтийг өссөн дүнгээр тайлагнасан.

4.1.1. Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Хүнс, хөдөө аж ахуйн газрууд Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хүнс, хөдөө аж ахуйн салбарт хамаарах арга хэмжээг хяналтад авч хэрэгжүүлж байна. Дэд хэсгийн хэрэгжилт 76.7-95.0 хувьтай дүгнэгдсэн ба дундаж үнэлгээ **88.3** хувьтай дүгнэгдсэн байна. /График-2/

График- 2



4.1.2. Үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн ЗД, ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжиж буй “Монгол мал”, “Сав баглаа боодол”, “Мах, сүүний анхдугаар аян”, “Төрөөс Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”, “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр” зэрэг дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт дунджаар **86.6** хувь гэж дүгнэгдсэн /График-3/. Дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн үнэлгээгээр Завхан аймаг хамгийн өндөр буюу **100.0** хувь, Өмнөговь, Говьсүмбэр аймгууд хамгийн бага хувьтай байна.

График- 3



4.1.3. Аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт

Аймгийн эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд тусгагдсан хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах 2 болон түүнээс дээш арга хэмжээ тусгагдсаныг хяналтад авч хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан байна. Дэд хэсгийн хэрэгжилт 70.0-100.0 хувьтай дүгнэгдсэн ба дундаж үнэлгээ **90.1** хувьтай байна. /График-4/ 90 хүртэл үнэлгээтэй 7 аймаг, бусад аймаг нь 90 хувиас дээш үнэлгээтэй байна.

Аймгуудын үндсэн чиглэлд тусгагдсан ХХААХҮ-ийн салбарт хамаарах арга хэмжээний тоо хэт өндөр зөрүүтэй байгаа нь төлөвлөлтийг үндэслэлтэй, судалгаанд тулгуурлан бодитой хийх шаардлага байгааг харуулж байна. Үндсэн чиглэл нь богино хугацааны бодлогын баримт бичиг бөгөөд нэг жилийн хугацаанд хэрэгждэг тул хэрэгжих боломжтой, тодорхой үр дүнд хүрэх, санхүүжилт шийдвэрлэгдсэн арга хэмжээнүүдийг оруулах нь зүйтэй юм.

График -4



4.2. Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ

Уг бүрэлдэхүүн хэсэг нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаас ХХААГ-ын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт, Аймгийн ХХААГ-аас Сумдын мал эмнэлэг, үржлийн тасагтай байгуулсан тухайн жилийн хамтран ажиллах гэрээний биелэлтийн дүн, Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлт гэсэн дэд хэсгүүдтэй ба “Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ” бүрэлдэхүүн хэсгийн дундаж үнэлгээ **84.9** хувьтай дүгнэгдлээ.

4.2.1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаас ХХААГ-ын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаас ХХААГ-ын даргатай байгуулсан 2017 оны үр дүнгийн гэрээний биелэлтэд аргачлалын дагуу яамны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрууд үнэлгээ хийж, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлсэн. Гэрээний үр дүнгийн дундаж үнэлгээ **80.2** хувьтай байна.

График- 5



4.2.2. Аймгийн ХХААГ-аас Сумдын мал эмнэлэг, үржлийн тасагтай байгуулсан тухайн жилийн хамтран ажиллах гэрээний биелэлтийн дүн

Аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газруудаас сумдын мал эмнэлэг, үржлийн тасагтай байгуулсан 2017 онд хамтран ажиллах гэрээг дүгнэсэн дүн дунджаар **82.9** хувьтай, үүнээс хамгийн өндөр үнэлгээтэй нь Өвөрхангай, Дорноговь аймгууд байна.

График- 6




4.2.3. Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлт

Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлтийг үнэлэхдээ байгууллагын үйл ажиллагаанд Үндэсний болон аймгийн аудитын газраас хийсэн санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын зөвлөмж болон удирдах дээд байгууллагаас хөтөлбөр, төслийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг харгалзан дүгнэлээ.

Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилт дунджаар 91.79 хувьтай үнэлэгдсэн ба Өвөрхангай 96.2, Дорнод аймаг 95.7, Говьсүмбэр аймаг 94.7, хувиар тус тус дүгнэгдэж бусад аймгуудаа тэргүүлсэн.

График -7



4.3. Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ

Уг бүрэлдэхүүн хэсгийн Хэрэглэгчийн үнэлгээ дэд хэсгийн дүнг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний тасгаас ирүүлсэн үнэлгээгээр авсан ба байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын тайланд яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар үнэлгээ хийв. “Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ” бүрэлдэхүүн хэсгийн дундаж үнэлгээ **84.7** хувьтай байна.

График -8



4.3.1. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын тайлан

Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийн биелэлт дунджаар **94.1** хувьтай үнэлэгдсэн. Баянхонгор, Сэлэнгэ, Орхон аймгуудын ХХААГ-ын цахим хуудасны ашиглалт, мэдээлэл түгээлт хангалттай байна.

ХХААГ-ууд байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарынхаа бүтэц, агуулгыг сайжруулан, цаг үеийн мэдээллээ тогтмол оруулж, төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хэрэглэгчдэд хүргэх талаар санаачлагатай ажиллан үйл ажиллагааны ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийг тайланд тусгахад анхаарах хэрэгтэй.


График-9



4.3.2. Хэрэглэгчийн үнэлгээ

Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйл ажиллагаанд өгсөн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдсан иргэдийн дундаж үнэлгээ **75.5** хувьтай байна. Хэрэглэгчийн үнэлгээгээр Сэлэнгэ аймаг хамгийн өндөр буюу **97.4** хувьтай дүгнэсэн. Увс, Дорнод, Орхон, Сүхбаатар аймгуудын хэрэглэгчийн үнэлгээний тайлан зохих аргачлалын дагуу хийгдээгүй, шаардлага хангахгүй байсныг тэмдэглэж байна.

График-10



4.4. Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ

Аргачлалд тусгагдсанаар уг бүрэлдэхүүн хэсэг нь хүнс, мал эмнэлэг, мал аж ахуй, газар тариалангийн салбар гэсэн дэд хэсгүүдтэй ба “Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ” бүрэлдэхүүн хэсгийн дундаж үнэлгээ **87.2** хувьтай байна.

График-11



4.4.1. Хүнсний салбар

Аймгуудын Хүнс Хөдөө аж ахуйн газрын хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр хийсэн ажлын ерөнхий үнэлгээ дунджаар 90.4 хувьтай дүгнэгдсэн байна.

ХХААХҮ-ийн сайдын 2017 оны А-159 дүгээр тушаалаар баталсан “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ын хавсралтын “Хүнсний салбарын үр дүнгийн үзүүлэлт”-ийг үнэлэх хүснэгтэд заасан (*) тэмдэглэгээтэй 10 үзүүлэлтийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хийв.

ХХААХҮ-ийн сайдын 2017 оны А-159 дүгээр тушаалаар баталсан аргачлалд хүнсний салбарын үр дүнгийн зарим үзүүлэлтийг шинэчилсэн. Хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнс үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр төрөөс авч хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээний үр дүнг бодитой үнэлэхийн тулд зээлдэгч - хүнс үйлдвэрлэгчийн үйлдвэрлэлийн хэмжээ, өсөлт ба хэрэглэгчийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр хийсэн ажил үзүүлэлтийг шинээр нэмж тусгасан болно.

2017 онд нийт 21 аймгийн ХХААГ-т орон нутгаас Хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр нийт 773 сая төгрөг зарцуулсан нь 2016 оныхоос (2 тэрбум 25 сая) 2,6 дахин нэмэгдсэн байна. Хүнсний салбарын 504 иргэн, аж ахуйн нэгжид 8 тэрбум 65 сая төгрөгийн зээл олгосон нь 2016 оныхтой (3 тэрбум 308 сая) харьцуулахад 2.4 дахин нэмэгдсэн эерэг үзүүлэлт байв. Гэвч хүнсний боловсруулах үйлдвэрийн нийт үйлдвэрлэл 2016 оныхоос (196 тэрбум 673 сая) 12.5 хувиар буюу 172 тэрбум 47 сая төгрөг болж буурсан байгаа нь зээлийн хэмжээ нэмэгдсэнтэй харилцан урвуу үзүүлэлттэй гарч үр дүнгүй ажилласан гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

Үзүүлэлт	ХАБ-ыг хангах чиглэлээр орон нутгийн хөрөнгө, сая төгрөг	Хүнс үйлдвэрийн салбарт олгосон зээл, сая төгрөг	Зээл авсан аж ахуйн нэгж, иргэний тоо	Нийт үйлдвэрлэл /Хүнсний боловсруулах үйлдвэр/ сая төгрөг	Нийт борлуулалт /Хүнсний боловсруулах үйлдвэр/ сая төгрөг
2016 он	773	3308	655	196673	189714
2017 он	2025	8065	504	172047	212920

Хүнсний аюулгүй байдлын чиглэлээр үзэсгэлэн худалдаа, сургалт зохион байгуулах, хэрэглэгчийн боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагаанууд нийт аймагт жигд гүйцэтгэлтэй байв. Харин орон нутгаас Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, үйл ажиллагаандаа зохистой дадал нэвтрүүлсэн хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч алга байгааг сүүлийн таван жилийн турш явуулсан сургалт сурталчилгаа, мэргэжил арга зүйгээр хангаж буй үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч болох нэг үзүүлэлт хэмээн дүгнэж байна.

Дорнод, Орхон, Хэнтий, Хөвсгөл, Ховд аймаг бусадтай нь харьцуулбал ХХААХҮ-ийн сайдын 2017 оны А-159 дүгээр тушаалаар баталсан аргачлалын заасны дагуу бодитой, үнэн тайлан ирүүлсэн гэж үзэх үндэслэлтэй байна. Гэвч ихэнх аймгууд Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 4.4 ба дээр дурдсан аргачлалын 6.1.1.1, 6.3.1-д заасныг зөрчиж үр дүнгийн үзүүлэлтүүдийг дутуу, хэмжих нэгжээс зөрүүтэй, тухайн оны үзүүлэлтэд тохируулж суурь түвшинг зориудаар бууруулсан, зарим үзүүлэлтийг хасч будилуулсан, математикийн энгийн үйлдлийн алдаа гаргасан зэрэг зөрчилтэй тайлан ирүүлсэн байна.

График-12



Зөвлөмж болгох нь

1. ХАБ-ыг хангах чиглэлээр олгосон орон нутгийн хөрөнгийн хэмжээ болон хүнс үйлдвэрийн салбарт олгосон зээлийн хэмжээ нэмэгдсэн байтал хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн нийт үйлдвэрлэлийн хэмжээ 12.5 хувиар буурсан байх тул зээлийн ашиглалтыг зөвхөн зээлийн эргэн төлөлтийн үзүүлэлтээр дүгнэх бус зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж буй байдал, олгосон хөрөнгө оруулалтын эрсдэл, зээлийн өгөөж

зэрэгт тавих хяналтыг сайжруулах, мэргэжил арга зүйгээр хангах, төсөл сонгон шалгаруулах ажилд ХХААГ-ын хариуцсан мэргэжилтнүүдийг татан оролцуулах, байгууллага хоорондын уялдаа холбоог нягтруулах санал санаачилга гаргах, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг оновчтой болгохыг;

2. Зээл авсан аж ахуйн нэгж, иргэдтэй байгуулах зээлийн гэрээнд үйлдвэрлэлийнхээ талаарх үнэн зөв, бодтой мэдээлэл авч байх тухай тусгайлсан заалт оруулах замаар хамтран ажиллахыг;

3. Сургалт, сурталчилгааны ажлын үр дүнг дээшлүүлэх зорилгоор хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч үйл ажиллагаандаа Хөдөө аж ахуйн, Үйлдвэрлэлийн зохистой дадал, Эрүүл ахуйн зохистой дадал нэвтрүүлэх заавал нэвтрүүлэх гэсэн Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр бодитой ажил хийж эхлүүлсэн байхыг;

4.ХХААХҮ-ийн сайдын 2017 оны А-159 дугаар тушаалаар баталсан “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу бодитой, үнэн зөв, иж бүрэн тайланг цаг хугацаанд нь тайлагнаж байхыг тус тус зөвлөмж болгож байна.

4.4.2. Мал эмнэлгийн салбар

Мал эмнэлгийн салбарын 2017 оны үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлэхдээ “Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ”, “Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ”, “Паразит өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээ”, “Ариутгал халдваргүйтгэл”, “Лабораторийн шинжилгээ”, “Мэдээ тайланд өгсөн Мал эмнэлэг, үржлийн газрын үнэлгээ”, “Тайлангийн агуулга, чанарт өгсөн үнэлгээ” зэрэг бүрэлдэхүүн хэсгүүдийн хүрээнд 13 шалгуур үзүүлэлтийг харгалзан хийлээ. Дэд хэсгийн хэрэгжилтийн үнэлгээ дунджаар **89.5** хувь буюу “хангалттай сайн”дүнтэй үнэлэгдсэн.

Халдваргүй өвчин мэдээлэл. Халдваргүй өвчний мэдээ ирүүлэлтийг аймгууд хагас, бүтэн жилээр хугацаанд нь ирүүлдэг боловч Төв, Орхон, Сэлэнгэ аймгууд төлийн халдваргүй өвчний мэдээг хугацаа хожимдсон, шаардуулж ирүүлсэн болохыг тэмдэглэж байна.

1.Паразиттах өвчний төлөвлөлт, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, мэдээ ирүүлэлтийн талаар. Паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөлтийг оны эхэнд сумдын МЭҮТасаг, МЭҮН-үүдтэй байгуулах гэрээнд тухайн сумын нийт мал сүргийн 30-аас доошгүй хувийг хамруулахаар төлөвлөн бод, бог, нохой, бусад гэж төрөлжүүлэн төлөвлөж, улирал бүрийн мэдээ гаргахад төлөвлөгөөтэйгөө харьцуулан биелэлтийг гаргаж байх шаардлагатай. Гэтэл төлөвлөгөөг МЭҮТ, МЭҮН-үүдтэй малын төрлөөр тохирч гаргадаггүй хайнга ханддаг учир бариммягаар төлөвлөгөө гаргаж, гүйцэтгэл тооцож байгааг аймгийн МЭХ-ийн дарга, паразит өвчин хариуцсан мэргэжилтнүүд онцгой анхаарна уу.

Мөн мал угаалга, хот бууц ариутгах ажил маш муу хийгдэж байгаа учир аливаа өвчний халдвар тархах нөхцөл бүрдэж байгааг ханаарч бог малыг бүрэн ноосолсон 7-9 сард ванндаж угаах, хөрзөнг ховхолж гаргасан хороо, хашааг хантал ариутгах ажлыг мөн энэ хугацаанд хийх, үхрийг нэг бүрчлэн гуурын үзлэгт хамруулж, гууртайг эмчлэн эдгэрүүлэх ажлыг сайн хийхийг зөвлөж байна.

Дархан-Уул, Өмнөговь, Ховд, Хөвсгөл аймгууд мэдээг хугацаанд нь сайн ирүүлдэг.Архангай, Дорнод, Төв аймгууд мэдээг хугацаанд нь ирүүлдэггүй.


2. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн мэдээ, мэдээлэл. Аймгууд МЭҮН-ийн мэдээг гаргаж ирүүлэхдээ стандартын шаардлагаар унаа, байргүй нэгжийн үнэлгээг хангалтгүй үнэлгээнд хамруулж, шаардлагыг сайжруулах хэрэгтэй байгаа юм. Гэтэл ийм нэгжийг сайн, дунд үнэлгээ өгсөнөөр мэдээ ирүүлдэг. 20 шахам жил хөгжиж байгаа хувийн Мал эмнэлэгт Стандартын шаардлагыг өндөр тавьж тэмээ, морь унаатайг унаагүйд тооцох, түрээсийн байранд үйл ажиллагаа явуулдаг бол байргүйд тооцох гэх мэт.

3. Гоц халдварт өвчний мэдээлэл. Өгсөн загварын дагуу цаг хугацаанд нь мэдээлэх, орон нутгийн нөхцөл байдлын мэдээллийг шуурхай солилцох, вакцинжуулалтын үйлчилгээний хөлсний материалыг шаардлагын дагуу бүрдүүлж ирүүлсэн зэрэг асуудалд анхаарч дүгнэв. Баянхонгор аймагт гоц халдварт өвчин бүртгэгдээгүй ч хяналтын цэг байгуулж, ажиллуулж байгаа төдийгүй, үүсэн нөхцөл байдлын мэдээллийг шуурхай солилцож ажилласан, Өвөрхангай, Төв аймагт хяналтын цэг байгаа ч хангалтгүй ажиллаж байна. Гоц халдварт өвчний нөхцөл байдлын мэдээллийг Нийслэл, Төв, Дундговь, Дорноговь аймгууд хүргүүлсэн загварын дагуу мэдээлж байсан бол Булган, Сэлэнгэ аймаг хойрго хандсан байна. Вакцинжуулалтын үйлчилгээний хөлсний материалыг цаашид бүрдүүлэхэд Архангай, Дорноговь, Увс, Баян-өлгий аймгууд анхаарч ажиллах шаардлагатай байна.

4. Ерөнхий Эмчийн албан даалгавар. 2014 онд Малын Ерөнхий Эмчийн албан даалгавар №02 “Мал эмнэлэг, ариун цэвэр, гарал үүслийн гэрчилгээ, түүнийг хэрэглэх журмын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” ажлын хүрээнд гэрчилгээний зарцуулалтын тайлан, мэдээг 2017 оны эцсийн байдлаар Завхан аймаг, Орхон, Дархан-Уул аймгийн Мал эмнэлгийн газар хугацаанд нь ирүүлсэн бол бусад аймгууд огт ирүүлээгүй байна.

5. Ариутгал, халдваргүйтгэлийн мэдээ. Мал, амьтны гоц халдварт өвчний нөхцөл зарим аймагт гарсантай холбогдуулан, хяналтын пост ажиллуулсан, Засгийн газрын 257, 284-р тогтоол гарсантай холбогдуулан улсын хэмжээнд ариутгал халдваргүйтгэлийн арга хэмжээнд хамрагдсан тоо хэмжээ нэмэгдсэн болно. Аймаг, орон нутаг өөрсдийн хөрөнгөөр болон төслийн шугамаар ариутгалын нэмэлт бодис авч хэрэглэсэн нь ажлын гүйцэтгэлд тусгагдсан болно.

6.Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний мэдээ. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд хийгдэх ажлын мэдээ, тайланг үндэслэн аймгуудыг шалгаруулсан болно. Ингэхдээ улирлын мэдээ, жилийн эцсийн мэдээнүүдийг цаг хугацаанд ирүүлсэн байгууллагуудад 1 оноо өгч, хугацаа хоцорсонд 0,9 оноо, ирүүлээгүй аймгуудад 0,5 оноо өгсөн. Зарим аймгуудын мэдээ өмнө улирлын мэдээнээсээ дараагийн улирлын мэдээ буурсан зэрэг зөрчлүүд гарч байсан. Жишээ нь Төв, Архангай, Хэнтий байна.



4.4.3. Мал аж ахуйн салбар

Мал аж ахуйн салбарын үзүүлэлт гэсэн хүснэгтийн дүнгийн нэгтгэлийг аймаг тус бүрээр гаргав. Мал аж ахуйн салбарын үзүүлэлтэд Хээлтэгч хээлтүүлэгчийн тохирооны тоо, өвөлжилтийн бэлтгэл ажлын биелэлт, малын өсөлт, нэг малаас авах ашиг шим, мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үзүүлэлт зэргийг багтаасан мэдээллийг ашигласан. Мал аж ахуйн салбарын ерөнхий үнэлгээг арван дөрөвдүгээр графикт үзүүлэв.

График -14



Аймгийн ХХААГ-аас ирүүлсэн Мал аж ахуйн салбарын үнэлгээ харьцангуй өндөр байсан, тухайлбал 91.1-121.8 хувь гэсэн үнэлгээтэй байсан. ХШҮДАГ-ын үнэлгээний явцад эдгээр тоон дүнгүүд харьцангуй буурсан. Тухайлбал үнэлгээний дүн 83.8-95.7 болж өөрчлөгдсөн байна. Үнэлгээний зөрүүг дөрөвдүгээр хүснэгтэд үзүүлэв.

д/д	Аймгийн нэр	Аймгийн ХХААГ-ын үнэлгээ, хувиар	ХШҮДАГ-ын үнэлгээ, хувиар	Үнэлгээний зөрүү, хувиар
1	Архангай	92.4	83.8	8.6
2	Баян-Өлгий	99.8	93.5	6.3
3	Баянхонгор	100.0	93.6	6.4
4	Булган	95.7	95.7	0
5	Говь-Алтай	121.8	89.6	32.2
6	Дорноговь	100.5	90.0	10.5
7	Дорнод	97.0	92.1	4.9
8	Дундговь	100.0	90.9	9.1
9	Завхан	95.2	90.6	4.6
10	Өвөрхангай	97.4	94.8	2.6
11	Өмнөговь	98.2	92.6	5.6
12	Сүхбаатар	98.6	93.1	5.5
13	Сэлэнгэ	91.1	90.4	0.7
14	Төв	98.4	84.7	13.7
15	Увс	110.9	94.1	16.8
16	Ховд	92.6	90.4	2.2
17	Хөвсгөл	93.5	94.2	-0.7
18	Хэнтий	99.4	94.0	5.4
19	Дархан-Уул	97.7	89.1	8.6
20	Орхон	91.7	90.0	1.7
21	Говьсүмбэр	100.0	90.8	9.2

Аймгуудын ХХААГ-аас ирүүлсэн Мал аж ахуйн салбарын үзүүлэлтүүдийг нэгтгэн гаргасан хүснэгтээс үзэхэд дараах асуудлууд дээр анхаарал хандуулах шаардлагатай байсан. Үүнд:

1. Архангай аймгийн сум, аймгийн түвшин дэх ажлын, малын тооны өсөлтийн, мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зэрэг 20 үзүүлэлтийн зорилтот түвшинг тодорхойлж ирүүлээгүй,

2. Говь-Алтай аймгийн тухайд Хээлтүүлэгч, хээлтэгчийн тохиорооны тоог гаргах 5 үзүүлэлтийн зарим зорилтот түвшнээс хүрсэн түвшний үзүүлэлт бага байхад өндөр хувьтай гэж тооцсон,

3. Дорноговь аймгийн ХХААГ-ын нэгтгэл хүснэгтэд 2-оос бусад бүх үзүүлэлтийн зорилтот түвшин болон хүрсэн түвшний тоон утга нь ижил буюу төлөвлөлтийг хэтэрхий хялбарчилсан,

4. Дорнод аймгийн өвөлжилтийн бэлтгэл ажлын биелэлтийг 100 хувь байхаар зорилт тавьсан ба сумдын хүрсэн түвшин 91.7 хувь, харин аймгийн өвөлжилтийн хүрсэн түвшин 342 хувь гэж тооцсон нь хэт өндөр алдаатай болсон,

5. Завхан аймгийн ХХААГ малын тооны өсөлт гэсэн үзүүлэлт дэх малын тооны өсөлт буурсан дүнтэй байна. Тухайлбал 2017 оны зорилтот түвшин 276.2 мянган толгой гэж

тооцсон бол хүрсэн түвшин 191.1 мянга толгой буюу биелэлт 69.2 хувь болжээ. Энд адуу, хонь, ямааны тоо толгойд өсөлт гараагүй гэсэн дүнтэй,

6. Сэлэнгэ аймгийн ХХААГ нь салбарын 14 үзүүлэлтийн зорилтот түвшний тоон үзүүлэлтийг гаргаагүй зөвхөн хүрсэн түвшний тоон үзүүлэлтийг гаргаж ирүүлсэн,

7. Төв аймгийн тухайд 2017 оны мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл дэх үхрийн шир, ямааны арьс, хонины нэхийний тоо ширхэгийг хугацаа болоогүй гэдэг шалтгаанаар тоо мэдээллийг гаргаж ирүүлээгүй,

8. Харин Увс аймаг мал аж ахуйн салбарын ерөнхий үнэлгээг 110.9 хувь, 16 үзүүлэлтийг 100 - аас дээш үнэлгээтэй гэж дүгнэсэн байх жишээтэй,

9. Ховд аймгийн ХХААГ нь сумдын түвшин дэх өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрэх түвшинг 100 хувь байхаар тооцсон, харин аймгийн хэмжээнд 80 хувь байхаар төлөвлөсөн нь доогуур үзүүлэлт гэж үзэхээр байна.

10. Хэнтий аймгийн ХХААГ нь малын тооны өсөлт буюу тэмээ, адуу, үхэр, хонь, ямааны болон мах, сүү, үхрийн шир, ямааны арьс, хонины нэхий бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн зорилтот түвшинг огт тодорхойлж гаргаагүй,

11. Дархан-Уул аймгийн ХХААГ салбарын 2016 оны суурь түвшнээс 8 үзүүлэлтийн зорилтот түвшинг доогуур төлөвлөсөн байна.

Эндээс үзэхэд дээрх нэр бүхий 11 аймаг Мал аж ахуйн салбарын үзүүлэлтийг нэгтгэн гаргах үйл ажиллагаанд алдаа гаргасан, харин бусад 10 аймаг салбарын үзүүлэлтүүдийг зохих түвшинд үнэлэж ирүүлжээ.

Мөн түүнчлэн мал аж ахуйн салбарын тоон үр дүнгийн нэгдсэн хүснэгтээс харахад 2017-2018 оны өвлийн бэлтгэлийг сайн хангасан дүн гарч байна. Тухайлбал өвөлжилтийн бэлтгэл ажлын биелэлт 88.4-100.0 хувьтай, энэ дүн бодит байдалтай хэрхэн нийцэж байгаа талаар тайлан мэдээ бэлтгэж ирүүлэх шаардлагатай болж байна.

Аймгийн ХХААГ-аас ирүүлсэн Мал аж ахуйн салбарын үнэлгээ харьцангуй өндөр буюу 91.1-121.8 хувьтай, өөрөөр хэлбэл ажлаа 121.8 хувь гэж үнэлсэн явдал гарч байгаад цаашид дүгнэлт хийх шаардлагатай, бидний одоо мөрдөж байгаа үнэлгээний хамгийн их тоон утга нь 100 хувь байна.

4.4.4. Газар тариалангийн салбар

Газар тариалангийн салбарыг үнэлэхдээ “Газар тариалангийн үйлдвэрлэл”, “Газар тариалангийн салбарын бүтээмж”, “Усалгаатай тариалан”, “Хамгаалагдсан хөрс”, “Зоорины хангамж”, “Сургалт”, “Тариалангийн газрын ашиглалт, зохион байгуулалтын чиглэлээр хийсэн ажлын үнэлгээ”, “Тайлангийн чанар” гэсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг шалгуур болгон хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ. Аймгуудын ХХААГ-ын 2017 оны газар тариалангийн салбарын ерөнхий дундаж **82.7** хувьтай үнэлэгдсэн байна.



2017 оны ургац хураалтын урьдчилсан дүнгээр нийтдээ 237.7 мянган тонн үр тариа, үүнээс 230.6 мянган тонн улаанбуудай, 116.8 мянган тонн төмс, 79.9 мянган тонн хүнсний ногоо, 12.5 мянган тонн тосны ургамал, 61.9 мянган тонн тэжээлийн ургамал тус тус хураан авсан байна. Түүнчлэн жимс, жимсгэнэ, хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор “Жимс, жимсгэнэ”, “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийг боловсруулж Засгийн газраар батлуулан хэрэгжилтийг зохион байгуулж эхлээд байна.

“Газар тариалангийн үйлдвэрлэл”-ийн үзүүлэлтийн дундаж үнэлгээ 82.7 хувьтай дүгнэгдсэн ба хамгийн өндөр үнэлэгдсэн нь Сэлэнгэ аймаг 93.8 хувь, Увс аймаг 92.1 хувьтай байна.

Газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, тайлагналтын сайжруулах чиглэлд дараах ажлыг зөвлөмж болгож байна. Үүнд:

1. Аймгууд төлөвлөгөөгөө боловсруулахдаа Төрөөс Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, Тариалангийн салбарын дэд хөтөлбөрүүд болон тухайн аймгаас тариалангийн талаар хэрэгжүүлж буй бодлогуудад тусгасан салбарын зорилт арга хэмжээтэй уялдуулан төлөвлөлтийг сайжруулахыг,
2. ХХААХҮ-ийн сайдын 2017 оны А/159 тушаалаар батлагдсан “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх” аргачлалын шалгуур үзүүлэлтийн хүснэгтийн дагуу тайлагналтыг сайжруулахыг,
3. Аймгууд 2017 онд тариалангийн газрын ашиглалт, зохион байгуулалтын чиглэлээр хангалттай ажлууд хийж гүйцэтгээгүй, тариалангийн талбайг ойжуулах, ойн зурвас байгуулах ажил хийгдэхгүй байгааг анхаарч ажиллахыг,
4. Тариалангийн салбарын үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналтыг сайжруулах чиглэлд аймгуудад дараах зөвлөмжийг өгч байна.

Архангай аймагт:

- Нийт усалгаатай тариалсан талбайн хэмжээ 546.7 га гэж тайлагнасан. Таримлын төрлөөр салгаад гарсан тоо нь 586 га болж нэмэгдсэнд,
- Нийт усалгаатай тариаланд таримлын эзлэх хувь төмс 70 хувь, хүнсний ногоо 90 хувь, бусад таримал 5 хувь, нийт 165 хувь гэж тайлагнасанд анхаарах,

- Гүйцэтгэлийн хувийг 100 хувиас дээш гаргаж тайлагнасан.

Баянхонгор аймагт:

- Газар тариалангийн салбарын шалгуур үзүүлэлтийн дагуу хүрсэн үр дүнг бүрэн, оновчтой тайлагнаагүй, үр дүнг тооцоход хүндрэлтэй байсныг цаашид засаж сайжруулахыг,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шинээр болон сэргээн засварласан услалтын системийн ашиглалтыг сайжруулахыг,
- Тариалангийн талбайн хэмжээ 1049 га-аас 760.8 га талбай болж 27.5 хувиар буурсанд дүгнэлт хийж ажиллахыг,
- 2017 оны хүрэх түвшинг тодорхой тусгаагүй байгаад,
- Газар тариалангийн салбарт 2017 онд 31.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн гэж тайлагнасан, хэмжих нэгжийг зөв бичиж тайлагнахыг,

Баян-Өлгий аймагт:

- Гүйцэтгэлийн хувийг 100-ас дээш хувиар тайлагнасан, жишээ нь 290, 281 хувь гэсэнд анхаарахыг,
- Зорилтот түвшинг өмнөх оны суурь түвшнээс бууруулж тооцсоныг анхаарч, ажиллахыг,
- Аймгийн газар тариалангийн үйлдвэрлэлийн эзлэх хувийг улсын хэмжээний үйлдвэрлэлтэй харьцуулж тооцоогүй байгаад,
- Техникийн шинэчлэл, тариалангийн газрын ашиглалт, зохион байгуулалтын чиглэлээр хангалттай ажлууд хийж гүйцэтгээгүйд,
- Газар тариалангийн салбарт 2017 онд 36.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн гэж тайлагнасан ба хэмжих нэгжийг анхаарч, хүснэгтийн дагуу тоог зөв тайлагнахыг,

Булган аймагт:

- Хүнсний ногооны хангамж, усалгаатай тариалангийн үзүүлэлтүүдийн биелэлт харьцангуй бага байна. Цаашид хүнсний ногооны хангамжийг нэмэгдүүлэх, усалгаатай тариаланг хөгжүүлэх чиглэлд анхаарахыг,
- ХХААХҮ-ийн сайдын 2017 оны А/159 тушаалаар батлагдсан аргачлал, шалгуур үзүүлэлтийн хүснэгтийн дагуу тайлагналтыг сайжруулахыг,

Дархан-Уул аймагт:

- Гүйцэтгэлийн хувийг 100-аас дээш хувиар гаргаж тайлагнасан. Тухайлбал 117.8 хувь, 161.4 хувь гэснийг анхаарахыг,

Дорнод аймагт:

- Усалгаатай талбайн ашиглалт, нэгжийн ургац, бүтээмжийг сайжруулахыг,
- Жимс, жимсгэнийн тариалалтын нэмэгдүүлэх тал дээр анхаарч ажиллахыг,

Дорноговь аймагт:

- Усалгаатай талбайн ашиглалт, нэгжийн ургац, бүтээмжийг сайжруулахыг,
- Усны зарцуулалтыг хэмнэлттэй ашиглах, арга, технологийг нэвтрүүлэхийг,

Дундговь аймагт:

- Гүйцэтгэлийн хувийг 100 %-иас дээш гаргаж тайлагнасан. 148.6 %, 279.0 % гэх мэт. 2017 онд Дундговь аймгийн газар тариалангийн салбарын шалгуур үзүүлэлтийн биелэлт 108.8 хувьтай тайлан ирүүлсэн.
- Газар тариалангийн салбарт орон нутгийн төсвөөс оруулсан хөрөнгө оруулалт 25.0 мянган төгрөг, зохион байгуулсан сургалт 9.5 тэрбум гэж тайлагнасан байна. Тооны орон нэгж анхаарах, төлөвлөлт, тайлагналтыг сайжруулах,

Говь-Алтай аймагт:

- Гүйцэтгэлийн хувийг 100 дээш хувиар тайлагнасан. Жишээлбэл **1786.0 хувь, 317.0 хувь**, газар тариалангийн салбарын шалгуур үзүүлэлтийн биелэлт 164.0 хувьтай гэсэн нь үнэхээр том алдаа байгаад анхаарч ажиллахыг,
- Гүйцэтгэлээ өндөр харагдуулахын тулд хүрсэн үр дүнгээсээ шалгуур үзүүлэлтээ бууруулж төлөвлөсөн, эсвэл хүрсэн түвшнөөр зорилтот түвшинг тайлагнасан зэрэгт хяналт тавьж ажиллахыг,

Говьсүмбэр аймагт:

- Зорилтот түвшинг хэт өндөр төлөвлөсөн, зарим тохиолдолд хүрсэн түвшингөөс бууруулсан зэрэг төлөвлөлтийн алдаа байгааг засаж, сайжруулахыг,

Завхан аймагт:

- Тариалангийн талбайг ойжуулах, ойн зурвас байгуулах ажил 2017 онд хийгдээгүй, мөн техникийн шинэчлэл хийгдээгүй байгаад анхаарч ажиллахыг,

Өвөрхангай аймагт:

- Техникийн шинэчлэлийн хувийг тооцохдоо хүсэн үр дүнгээ хувиар илэрхийлээгүй, мөн түүнчлэн зүтгэх хүч гэснийг 178 хувиар шинэчлэгдсэн гэж алдаатай тайлагнасныг,

Өмнөговь аймагт:

- Төмсний хангамж өмнөх онтой харьцуулахад буурсанд, хүнсний ногоо жимс, жимсгэнийн тариалалтын нэмэгдүүлэх чиглэлд анхаарч ажиллахыг,
- Тухайн жилийн жимс, жимсгэнийн хангамжийн улсын хэмжээнд эзлэх хувь 0.5 хувийн биелэлттэй байгааг дээшлүүлэхийг,

Сүхбаатар аймагт:

- Аймгийн газар тариалан хариуцсан мэргэжилтэн жимс, жимсгэнэ хураан авсан ургацыг тайлагнахдаа статистик дүн мэдээ гараагүй байна гэж тайлагнасан, 40 га талбайн мэдээг сумдаас авах боломжтой байгааг хэт хүндрүүлсэн явдалд анхаарахыг,

Сэлэнгэ аймагт:

- Жимс, жимсгэнийн ургацыг нэмэгдүүлэх, тогтвортой ургац авахад анхаарч ажиллахыг,

- Хамгаалагдсан хөрсний тариалалтын шалгуур үзүүлэлт тус бүрээр төлөвлөхдөө алдаа гаргаснаас болж үзүүлэлт багаар үнэлэгдэх нөхцөл үүсэж байгааг, цаашид нийт хамгаалагдсан хөрсний тариалалтаа 100 хувь байхаар төлөвлөж ажиллахыг,

Төв аймагт:

- Нийт хамгаалагдсан хөрсний тариалалтад өвлийн хүлэмжийн эзлэх хувь болон техник шинэчлэлийн хувийг хэт өндрөөр төлөвлөжээ. 2017 онд олон тооны техникийн парк шинэчлэл хийсэн хэдий ч төлөвлөлтөө 20 орчим хувиар хийсэн нь үр дүн буурахад нөлөөлсөн, улсын хэмжээнд жилд дунджаар 5 орчим хувиар техникийн шинэчлэл хийж байгааг анхаарч ажиллахыг,

Увс аймагт:

- Гүйцэтгэлийн хувийг 100 -аас дээш хувиар тайлагнасан. Тухайлбал 183.6, 205.0 хувь, гэх мэт бичсэнийг засаж сайжруулахыг,
- Нийт хамгаалагдсан хөрсний талбайн эзлэх хувь 2017 оны жилийн эцсээр 102.8 хувь болсон зэрэг тайлагналтын алдааг засахыг,

Ховд аймагт:

- Зоорины хангамж 2016, 2017 онд 47 хувийн хангамжтай байхад, хангамжийг нэмэгдүүлэхийг, жимс жимсгэнийн тариалалтыг өсгөхийг, техникийн хангамжийг сайжруулах чиглэлд үр дүнтэй ажил төлөвлөхийг,
- Өмнөх оны хүрсэн түвшинг тухайн жилийн зорилтот түвшин болгон төлөвлөсөн мөн хүрсэн үр дүн зорилтот түвшнээс бүгд давсан үзүүлэлттэй бөгөөд төлөвлөлтийн алдаа байгааг сайжруулахыг,

Хөвсгөл аймагт:

- Аймгийн газар тариалангийн үйлдвэрлэлийн хэмжээ улсын хэмжээний үйлдвэрлэлд эзлэх хувийг тодорхойлж дараагийн тайланд тусгах, дотоодын үйлдвэрлэлээр аймгийн хэрэгцээг хангах тал дээр анхаарч ажиллахыг,

Хэнтий аймагт:

- Гүйцэтгэлийн хувийг 100-аас дээш гэж тайлагнасан, жишээлбэл 107.7 хувь, 140.0 хувь гэснийг,

Орхон аймагт:

- Зорилтот түвшинг өмнөх оны хүрсэн түвшингөөс бууруулж тооцсон төлөвлөлтийн алдааг залруулахыг,
- Үнэлгээ гарсан шалгуур үзүүлэлтүүдийн дунджаар ерөнхий дүн гарна. Өөрийн дүнг бууруулж тайлагнасныг сайжруулж ажиллахыг тус тус зөвлөмж болгож байна.

4.4.5. Хөнгөн үйлдвэр, жижиг дунд үйлдвэр, хоршооны салбар

Аймгуудын Хүнс, Хөдөө аж ахуйн газрын хөнгөн үйлдвэр, жижиг дунд үйлдвэр, хоршооны чиглэлээр хийсэн ажлын ерөнхий үнэлгээ дунджаар 86.3 хувьтай байна.

Хөнгөн үйлдвэр, жижиг дунд үйлдвэр, хоршооны салбарын үр дүнгийн үзүүлэлтийг үнэлэх хүснэгтийн дагуу 13 чиглэлээр 55 үзүүлэлтээр үнэлж, хяналт-шинжилгээ, үнэлгээг хийв.



Орон нутгаас хөнгөн үйлдвэр, жижиг дунд үйлдвэр, хоршооны салбарт үзүүлсэн дэмжлэг, үйлдвэрлэл, хүчин чадлын ашиглалт, орон нутгийн үйлдвэрлэл, экспорт, импортын хэмжээ, зохион байгуулсан сургалт, үзэсгэлэн худалдаа, хамрагдагсдын тоо, зарцуулсан хөрөнгө, урамшуулалд хамрагдсан байдал зэрэг багц үзүүлэлтээр үнэлсэн.

Жижиг, дунд үйлдвэр, хоршооны салбарын үзүүлэлтээр хамгийн өндөр үнэлэгдсэн нь Өвөрхангай аймаг 94.6 хувь, Дундговь аймаг 91.8 хувьтай байна.

Өвөрхангай, Төв, Дундговь зэрэг аймгуудын хөнгөн үйлдвэр, жижиг дунд үйлдвэр, хоршооны чиглэлээр ирүүлсэн тайлагналт харьцангуй сайн байлаа.

Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Дундговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Увс, Ховд, Орхон зэрэг аймгууд түүхий эдийн үнийн мэдээгээ ирүүлж тогтмолжсон. Аймгууд 2017 онд жижиг дунд үйлдвэрийг дэмжих, хоршоо хөгжүүлэх чиглэлээр ажлууд хийж гүйцэтгэсэн боловч тайлагналт хангалтгүй байв. Ихэнх аймгууд түүхий эдийн үнийн мэдээгээ тогтоосон хугацаандаа ирүүлдэггүй, удаа дараа шаардуулж ирүүлдэг.

Зарим аймгууд нь 2017 оны хүрэх түвшинг тодорхой тусгаагүй, хэмжих нэгжийг буруу бичсэн төдийгүй гүйцэтгэлийн түвшинг 100 -аас дээш хувиар үнэлж тайлангаа ирүүлсэн. Жишээлбэл 161.2, 159.7, 158.1 хувь гэж ирүүлсэн байна.

Хөнгөн, жижиг дунд үйлдвэр, хоршооны салбарыг шинэ аргачлалаар, анх удаа дүгнэж байгаа бөгөөд алдаа дутагдал, сайжруулах зүйлс нилээд илэрч байна. Иймд хөнгөн, жижиг дунд үйлдвэр, хоршооны салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, тайлагналтыг сайжруулах чиглэлд дараах ажлуудыг хийх шаардлагатай гэж үзлээ. Тухайлбал:

1. ХХААХҮ-ийн сайдын 2017 оны А/159 тушаалаар батлагдсан “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх” аргачлалын шалгуур үзүүлэлтийн хүснэгтийн дагуу гаргах тайлагналтыг үнэн зөв гаргаж ирүүлэхийг,

2. Аймгуудын ХХААГ нь тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахдаа салбарын бодлогын баримт бичигт тусгасан арга хэмжээтэй уялдуулан төлөвлөж, хэрэгжилтийг үнэн зөв тайлаж байхыг,

3. Аймгууд 2017 онд жижиг дунд үйлдвэрийг дэмжих, хоршоо хөгжүүлэх чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлаа бүрэн тайлагнахыг,

4. Түүхий эдийн үнийн мэдээгээ тогтоосон хугацаандаа ирүүлж байхыг тус тус зөвлөмж болгож байна.

ДУГНЭЛТ

1. Аймгуудын хүнс, хөдөө аж ахуйн газрын 2017 оны үйл ажиллагааны гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний ерөнхий дундаж **86.73** хувьтай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 3.83 пунктээр өссөн дүнтэй байна

2. Аймгуудын ХХААГ-ын 2017 оны ажлын үр дүнгийн үнэлгээг 2 дугаар хүснэгтэд үзүүлсэн бөгөөд бүх аймаг 80 хувиас дээш үнэлгээтэй гарч байна. Тухайлбал Архангай аймгийн ХХААГ-ын үр дүнгийн үнэлгээ 82.48 (В), харин Өвөрхангай аймгийн ХХААГ хамгийн өндөр буюу 90.14 (А) үнэлгээтэй байна. Манай газар (А) болон (В) үнэлгээ авсан газруудыг 1-ээс 21 хүртэл эрэмбэлсэн. Энд 21 дүгээр байрт эрэмблэгдсэн ХХААГ нь (В) буюу “Сайн” гэсэн үнэлгээтэй байгааг тэмдэглэж байна.

3. ХХААХҮ-ийн салбаруудын одоогийн суурь түвшинг судалгаа тооцооны үндсэн дээр бодитой тогтоож, суурь түвшнээс хамаарсан төлөвлөлтийг үндэслэлтэй боловсруулж хүрэх түвшинг тодорхой тогтоож, үр дүнг зөв тайлагнаж, тоонд биш чанарт анхаарч ажиллах шаардлагатай байна.

4. Аймгуудын ХХААГ-ын тайлангийн нэгтгэл хүснэгт дэх хэмжих нэгж буюу тоо, мянган толгой, мянган тонн, мянган ширхэг зэргийг илэрхийлэх тоон утгыг нэгдсэн байдлаар Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал, 5.3.1.4 дэх заалт, “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу бичиж тайлагнах хэрэгтэй байна.

5. Аймгууд төлөвлөгөөгөө боловсруулахдаа Төрөөс Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, салбарын дэд хөтөлбөрүүд болон тухайн аймгаас баримталж буй бодлогын баримт бичигт тусгасан салбарын зорилт арга хэмжээтэй уялдуулан төлөвлөх шаардлагатай байна.

6. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг өссөн дүнгээр тайлагнаж байна. Цаашид тухайн тайлант жилийн дүнг аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсээр баталгаажуулж ирүүлэх шаардлагатай юм. Тухайлбал Дорноговь, Дорнод, Сэлэнгэ аймгууд, аймгийн ЗДТГ-ын ХШҮДА-ын хэлтсээр тайлангаа баталгаажуулж ирүүлээгүй, мөн Архангай, Өвөрхангай, Төв, Хөвсгөл аймгууд аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн биелэлтийг өссөн дүнгээр тайлагнаж ирүүлсэн байх жишээтэй.

ЗӨВЛӨМЖ

ХХААХҮ-ийн яамны хэрэгжилтийн газарт

1. Аймаг, орон нутагт хэрэгжүүлсэн “Монгол мал” хөтөлбөр, “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийн төлөвлөгөөний хэрэгжилт, бодит үр дүн, аймгийн хэмжээнд өрх, аж ахуйн нэгжид үзүүлсэн эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр үзүүлсэн дэмжлэг, бэлчээрийн усан хангамжийн талаар хийгдсэн аймаг, орон нутаг малчдын хөрөнгө оруулалт зэргийг нэгтгэж хүнс, газар тариалан, мал аж ахуй, хөнгөн үйлдвэрийн, хоршоо, үйлчилгээний, мал эмнэлгийн салбарын чиглэлээр гаргаж ажиллахыг тус яамны Бодлогын болон хэрэгжилтийг зохицуулах газрын дарга нарт,

Аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газарт

1. Сум, орон нутаг, хөдөөгийн бэлчээр дэх инженерийн хийцтэй худгийн ашиглалт, хамгаалалтын талаар бүрэн судалгаа гаргаж, худгийг аль улиралд болон бэлчээрийг хуваарьтай ашиглах төлөвлөгөө гаргаж ажиллах, мөн худгийг орон нутгийн өмчид бүртгүүлэх ажлыг тухай бүрд нь хийж байхыг,

2. Хур бороо, үерийн усыг ашиглах талаар иргэд, малчдын идэвх санаачлагыг өрнүүлэн ажиллаж бэлчээрийн усан хангамжийг хямд төсөр аргаар нэмэгдүүлэхийг, түүнчлэн усалалтын системийн ашиглалтыг сайжруулж усалгаатай тариалан эрхлэлтийг нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг,

3. Аймаг, орон нутаг дахь “Агропарк” байгуулах чиглэлээр нийлүүлэгдсэн трактор, хүлэмж, зоорийн ашиглалтын талаарх нэгдсэн судалгаа гаргаж, ашиглалтгүй тоног төхөөрөмжийг данснаас хасах, худалдах, шилжүүлэх, актлах, өмчлүүлэх тухай санал боловсруулж холбогдох байгууллагад танилцуулж шийдвэрлүүлэх арга хэмжээ авахыг,

4. Мал ээмэгжүүлэлт, бүртгэлжүүлэлтийн ажлын программ хангамж, мэдээллийн сүлжээний ашиглалтыг эрс сайжруулан Мал, эмнэлэг үржлийн газартай нягт хамтран ажиллан энэ ажлын үр дүн, үр нөлөөг дээшлүүлэхийг,

5. Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Мал хамгаалах сан, Жижиг дунд үйлдвэрийн дэмжих сангаас иргэн, аж ахуйн нэгжид олгосон зээлийн ашиглалт, зориулалт, эргэн төлөлтийг сайжруулахыг тус тус зөвлөмж болгож байна.

Зөвлөмжийн хэрэгжилтийг хагас бүтэн жилээр гаргаж Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлнэ үү.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ГАЗАР